



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/66

Ховд

Эрх шилжүүлэх тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хар-Ус нуурын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны Мянгад суманд хамаарах хэсэгт ажиллаж буй байгаль хамгаалагчдын байр /сандвич/ барих ажилд зориулан 13 121 662 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 13 121 662 төгрөг /арван гурван сая нэг зуун хорин нэгэн мянга зургаан зуун жаран хоёр/-ийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 4.18-д тусгагдсан арга хэмжээнээс санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Дээрх арга хэмжээг батлагдсан төсвийн хүрээнд "Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээг худалдан авах тухай хууль"-ийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчтэй хамтран ажиллах гэрээг байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих, хүлээн авах, тайлагнах эрхийг Хар-Ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны газрын дарга /С.Батмөнх/-д шилжүүлсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

Zax A/66 Ch

02 0575